10 ДУГААР АНГИЙН МХБУЗ-ЫН ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ХАРИУ

ХУГАЦАА: 80 МИН **ХУВИЛБАР А** НИЙТ: 40 ОНОО

1. **Хөрөг найруулал бичээрэй. (10 оноо) Үгийн тоо 200-250**

- Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд болон өгүүлбэр цогцолборын агуулгын уялдаа холбоо зөв болсон уу?
- Сэдэвтээ тохирсон агуулгаа оновчтой гаргаж чадсан уу?
- Сэтгэгдэл мэдрэмжээ оруулан оновчтой үг хэллэгээр гарган бичиж чадсан уу?
- Дүрслэлийг оновчтой сонгон хэрэглэж чадсан уу
- Зөв бичих дүрмийн хувьд алдаагүй байж чадсан уу гэх мэт шалгуурыг хангаН бичээрэй.

**Эхэд суурилан гүйцэтгэх даалгавар**

**Удган ээрүүл /Хас ба хос/**

... Европ зүгт зөвхөн эр бэлгэ, Дорно дахинд эр, эм бэлгэ хоёул буй бөгөөд соёл, ахуй судлалын үүднээс энэ нь гүнзгий агуулгатай, зарчмын үзэгдэл болохыг дараах бүлгүүдээс үзмүү. “Ёсгүй ёс гэж байхгүй гэсэн хуучны үг нар зөв эргэх монгол заншлын тухайд туйлын сонин учир холбогдолтой. Юу гэвэл нар зөв, буруу эргэх нь ертөнцийн орон зай, цаг хугацааны доторх физик үзэгдлийнхээ хувьд тэс өөр зүйл болохыг профессор Н.Козыров нарийн туршилтаар харуулж чадсан юм. ***Нар зөв эргэх физик хөдөлгөөн нь дэлхий дээрх цаг хугацааны чиглэлтэй зохирч, улмаар энерги хуримтлуулах арга болдог байхад нар буруу эргэхэд энерги алддаг нь гироскоп /удган ээрүүл/-оор хийсэн туршилтын хэмжилтээс тод илэрсэн байна.*** Тэгэхээр баруун, зүүн зүг ч адил бус физик утгатай байж болно... /Ч.Эрдэнэ

2. Эхэд буй онцолсон өгүүлбэр ойролцоо эсрэг, зүйлчилсэн, төсөөт өгүүлбэрийн алин болохыг тодорхойлж, хэдэн энгийн өгүүлбэр болох, ямар нөхцөл, холбох үгээр холбогдож байгааг тайлбарлан бичээрэй. (4 оноо)

   - Өгүүлбэрийн утга........ЭСРЭГ УТГА................
   - Энгийн өгүүлбэр.. ***Нар зөв эргэх физик хөдөлгөөн нь дэлхий дээрх цаг хугацааны чиглэлтэй зохир....***
   - ***энерги хуримтлуулах***
   - ***арга болдог байх***
   - . ***нар буруу эргэхэд энерги алддаг нь***
   - ***гироскоп /удган ээрүүл/-оор хийсэн***
   - ***туршилтын хэмжилтээс тод илэрсэн байна. ЭНГИЙН ӨГҮҮЛБЭР 6 БАЙНА.***
   - Өгүүлбэрийг холбох нөхцөл, холбох үг ......-ч, улмаар, бай-х-д, алд-даг хий-сэн Холбох хэрэглүүр 2 оос доошгүй бичсэн бол оноог бүтэн өгнө.

3. Тодруулсан өгүүлбэрийн “...зохирч, улмаар, хуримтлуулах, болдог байхад” гэх мэт үгсийг ойролцоо утгат үгээр солин найруулж төгс өгүүлбэр бүтээгээрэй. (4 оноо)

   Зохирч- таарч, нийцэж,

   Улмаар – цаашид, ийнхүү,

   Бай-х-д – бол

Хуримтлуулах – цуглуулах, бөөгнүүлэх

Цэгийн оронд тохирох бүтээврүүдийг дараалаар нь сонгон цагийн утга бүхий төгс өгүүлбэр бүтээн зөв бичээрэй. (4 оноо)

“Нар **НЫ** илч буур **Х**.д навч шарла..**Н**. ногоо ганд.**ЛАА**....” А.-ын,-сан,-саар, даг

В.-аас,-х,-тал, в **С.-ы,-х,-н, -лаа** D.-аар,-хуйц,-ж, на Е.-тай,-х,-магц, даг

4. Зөв бичих дүрмийн тайлбарт тохирох зөв хувилбарыг ялган үсэг тоог харгалзуулан бичээрэй. (2 оноо)

| | Дүрмийн тайлбар | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|---|
| A | **Цагт нэрийн “сан” нөхцөлийг буруу залгаж бичсэн үг** | Явсныг | очсноос | хаасны | Олдсоныг |
| B | **“ыг” нөхцөлийг залган бичих үг** | Гавж | хуш | унь | Орц |
| C | **Үйлийн болзохын –вал нөхцөлөөр хувилгах үг** | Сал | өг | хуул | Хөв |
| D | **Балархай эгшиг нь гээгдэх үг** | Ахиц+аар | Нөхцөл+ийг | Хоног+ийн | Үүрэг+ээр |
| **Харгалзуулан бичээрэй6 Зөв хариулт** | | **A2, B4,C2, D4** | | | |

5. “саналаар” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарлан бичээрэй.(2оноо)

**Ялгах эгшгийн үүргээр орсон балархай эгшгийг гээхгүй**

6. Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлгийг хам сэдвийн хүрээнд эргэцүүлэн үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлс дундаж наслалт, боловсрол, амралт, эрүүл мэнд, соёл, хооллолт талаар өөрийн ойлголтоо жишээ татан бичээрэй. (5 оноо)
   - **Өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий амьдралыгүзэх үзэлтэй.**
   - **Амьдралын чанар гэдгийг сэтгэлийн амар амгалантай холбож ойлгодог.**
   - **Гэрийн хүмүүжлийг ямагт дээдэлдэг.**
   - **Байгальтайгааойр байхыг эрмэлздэг.**
   - **Байгаль цаг уураа шинжсэнээр амьдралынхаа хэмнэлийг тохируулж чаддаг зэрэг нь нүүдэлчин монголчуудын хувьд үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсийг тодорхойлж чадах юм.**
   - **Дараах хэсгээс эшлэн бичсэн байвал оноог бүтэн өгнө.**

Хүний дундаж наслалт ...

Хөхөрсөн мод цэцэглэж, хүүхэд багачууд наадах дор

Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана...

Боловсрол ...

Зургаан мичид орой дээр, зулын гэрэл хажуу дор

Хөгшид өвгөд галыг базаан, хуучин үгсийг ярилцана...

Эрүүл мэнд

• ...Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана...

• ...Гэртээ суусан малчин түүнийг чагнан уярна....

Соёл • ...Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүх дор

Идэр залуус алс газрыг сонирхон, сурахаар одно...

• Өвлийн шөнө тэнгэрийн одод оч мэт гялалзахуйяа

Уудам тал дор жинчин хүний дуулах яруу...

• ...Үзэсгэлэнт уул, тунгалаг ус зуны цаг дор тэгш

Эрийн гурван наадам Монголын манлай баясгалан...

• ...Хүүхэд багачуудын гийнгоолох дуу хөндий тал дор яруу

Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал...

Амралт • ...Энх улирал ханхлах дор хүний сэтгэл тэнэгэр...

• Хээрийн галуу айлчлан ирж, гангар гунгар донгодохуйяа

Гэртээ суусан малчин түүнийг чагнан уярна...

Хоол хүнсний зардал

• ...Эхнэр хүүхэд аарц нэрж, түүнийг хүлээнэ...

• Өрх бүрийн үүднээ айраг найрын үнэр сэнгэнэнэ

Ийнхүү сайхан ба баясгалантай, тийнхүү сайхан жаргалтай

7. Машука хааны охиноо үдэж явуулахдаа хэлсэн үгийг зөв тохируулж бичээрэй. (2оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Зэргийн олон хатадтай | A | Оройн гавал мэт хүндэлж зохио |
| 2 | Номт түшмэдтэйгээ | B | Ах дүү мэт ханилж зохио |
| 3 | Доод албатууддаа | C | Шувууны далавч мэт атаагүй зохио |
| 4 | Ариун дээд номын нөхрийг | D | Эх мэт энэрч зохио |

**1C, 2B, 3D,4A**

8. Дараах хүмүүсээс ямар ямар овогтон үүссэнийг нөхөж бичнэ үү. (2 оноо)

Бүгүнүтэй ...........**БҮГҮНҮД..**................ Бухату салжи ..............**САЛЖИД**.............

Буха хатаги ........**ХАТАГИН**............... Бодончар мунхаг .......**БОРЖИГОН.**.....

9. Дараах эхийг кирилл бичгээр хөрвүүлэн бичээрэй. (5 оноо)

[illegible]

.....намайг бага байхад ах минь гурил зуурч, эгч элдэнэ. Ахын зуурсан гурил цав цагаан, голын захын чулуу шиг мөлгөрхөн хавтгай, бариад үзэхэд бүлээхэнбайдаг сан. Эгч ахын зуурсан гурилыг шууд элддэг атлаа миний зуурсан гурилыг нухаж байж элддэг нь гагцхүү халуун хүйтний зөрүүнд байна даа гэж боддог байв.

**Алдаатай үг бүрээс 0,25 оноо хасаж тооцно.**

10 ДУГААР АНГИЙН МХБУЗ-ЫН ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ХАРИУ

ХУГАЦАА: 80 МИН **ХУВИЛБАР Б** НИЙТ: 40 ОНОО

1. **Хөрөг найруулал бичээрэй. (10 оноо) Үгийн тоо 200-250**

- Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд болон өгүүлбэр цогцолборын агуулгын уялдаа холбоо зөв болсон уу?
- Сэдэвтээ тохирсон агуулгаа оновчтой гаргаж чадсан уу?
- Сэтгэгдэл мэдрэмжээ оруулан оновчтой үг хэллэгээр гарган бичиж чадсан уу?
- Дүрслэлийг оновчтой сонгон хэрэглэж чадсан уу
- Зөв бичих дүрмийн хувьд алдаагүй байж чадсан уу гэх мэт шалгуурыг хангаж бичээрэй.

**Эхэд суурилан гүйцэтгэх даалгавар**

Байгалийн аюулгүй байдлын тэнхлэг харьцаа

Нялхсын хүн болох зам нь өлгийдөө эхэлдэг. Хүн төрөлхтний өлгий нь энэхэн эргэлдэгч замбуулин. Нялхас мэндлэх бүрийд шинэ өлгий хийгээд байж болно. Харин хүн төрөлхтөнд өлгий болсон дэлхий ганцхан. Түүнийг хүүхдийн өлгий шиг шинэчлээд байх аргагүй. Эх дэлхий маань эргэлдэх тоолонгоороо "хуучирч, хөгширч" байгаа. Тэр хэзээ ч буцаад залуужихгүй. Манцуйтай нялхас хэчнээн учир мэдэхгүй, зүггүй байлаа ч өлгийгөө урж тасдахгүй. **Харин хүн төрөлхтөн ухамсартай эрдэмтэй болох тусмаа өөрт заясан ганцхан өлгий-бяцхан бөмбөрцгөө хүрзээр сийчиж, өрмөөр нүхэлж, бөмбөгөөр тэсэлж, цөмийн галаар хайрч, химийн урвалаар хордуулж, зүлэг ногоогий нь халцалж, ой модыг нь хяргаж, ан амьтны нь егүүтгэж, эрдэс баялгийг нь цөлмөж, агаар амьсгалыг нь бузарлаж, баян бүрдийг нь элсэн цөл болгож, уул толгодыг тэгшилж, ус нуурыг ширгээж, талыг там болгосоор байна.** Гэвч тэр хүн төрөлхтөн гэгдсэн хоёр хөлтний шунал зогсох шинжгүй улам шуналтай, улам халгаатай, улам хөнөөлтэйгээр өлгийгөө сүйтгэсээр байна. Тэдний дотор хүн толгойтны анх мэндэлсэн, бас хүйгий нь хадгалсан хоёр өндөрлөгийн нэгийг эртний ерөөлөөр эзэгнэн сууж буй монголчууд "тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх вэ" гэх шиг хамгийн сүүлд хэдхэн жилийн өмнө уулгалан ухасхийж хөнөөлтнүүдтэй нэгдэн нийлжээ. "Оройхон гараад ширүүхэн дайрна" гэдэг шигээ газар шороорууга гар далайсан байтлаа монголчууд хэнтэй ч зүйрлэшгүй хорлонтойгоор эх байгальдаа халдаж, харсаар ахуйд өрлөг ээжийнхээ буянт царайг зэрлэгээр самардан урж эхэллээ...

2. Эхэд буй онцолсон өгүүлбэр ойролцоо эсрэг, зүйлчилсэн, төсөөт өгүүлбэрийн алин болохыг тодорхойлж, хэдэн энгийн өгүүлбэр болох, ямар нөхцөл, холбох үгээр холбогдож байгааг тайлбарлан бичээрэй. (4 оноо)

   - Өгүүлбэрийн утга...**ОЙРОЛЦОО УТГА**...
   - Энгийн өгүүлбэрийн тоо................**16**.......өгүүлэхүйн төвөөр тоолж гаргасан эсэхийг харна
   - өгүүлбэрийг холбох нөхцөл, холбох үг ........**ТУСМАА, -Ж,Ч**.................

3. Тодруулсан өгүүлбэрийн "...сийчиж, болох тусмаа, егүүтгэж, бузарлаж" гэх мэт үгсийг ойролцоо утгат үгээр солин бичээрэй. (4 оноо)

   - СИЙЧИЖ- ХҮҮЛЖ, УРЖ, ТАСДАЖ,
   - БОЛСОН ХЭДИЙ Ч, БОЛОХ ТУТАМ,
   - УСТГАЖ, ХОРООЖ
   - БОХИРДУУЛЖ

4. Цэгийн оронд тохирох бүтээврүүдийг дараалаар нь сонгон цагийн утга бүхий төгс өгүүлбэр бүтээн зөв бичээрэй. (4 оноо)

“Салхи сэвэлз..., навч... хийсэх... шувууд буц.......”

..........................................................................................................................................

А. -ээд,-ууд,-д, даг В.-ж,-нууд,-ээр, лаа ***С.-н,-с,-д, на*** D.-сээр,-с,-тэл, жээ Е.-х,-с,-д, в

5. Зөв бичих дүрмийн тайлбарт тохирох зөв хувилбарыг ялган үсэг тоог харгалзуулан бичээрэй. (2 оноо)

| | Дүрмийн тайлбар | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|---|
| A | **Эр үгэнд “ы” бичих үг** | угж | урц | Булаг | байшин |
| B | **Ь тэмдэг и болох үг** | Ахь+ж | Шаагь+ж | Тарь+ж | Зорь+ж |
| C | **Ялгах эгшиггүй үг** | агна | ботго | Мөргөл | хоног |
| D | **“-л” ардаа эгшигтэй бичигдэх үг** | Борц+л | Тос+л | Нoорог+л | Онц+л |
| **Харгалзуулан бичээрэй.** | | **А2, В1, С3, Д3** | | | |

6. “хорголыг” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарлан бичээрэй.(2оноо)

**ЯЛГАХ ЭГШГИЙН ҮҮРГЭЭР ОРСОН БОГИНО ЭГШГИЙГ ГЭЭХГҮЙ**

7. Д.Равжаагийн Дөрвөн улирал шүлгээс улирал бүр дэх хүний амьдралын онцлогийг харуулсан хэсгийн гол санааг тайлбарлан бичээрэй. (5 оноо)

**Өсөх цаг : Гэнэн томоогүй , аливааг гэгээлгээр хардаг хүүхэд нас.**

**•Идэр цаг: Хийж бүтээхийн эрч хүчтэй ч алдаа ихтэй. Өөртөө итгэлтэй, бардам нас юм. •Өтлөх цаг: Алдаа оноогоо цэгнэж, аливаад ул суурьтай хандаж, буруу зөвийг дэнслэх нь их болдогухаарахнас.**

**•Өнгөрөх цаг:Биеийн болон ухааны тамир барагдаж, өвдөх нь их болох. Үхэх ирнэ гэдгийг хүлээн зөвшөөрдөг нас**

8. Машука хаан охиныхоо үгийн хариуд “... тийм муу цаг болсон тул ... туршиж асуусан бүлгээ. Алаг үгүй шударга явдал шүтэж чадахыг мэдэж,.. сэтгэл минь үнэхээр баясаж байна” гэж хэлдэг. Тийм муу цаг гэсний өмнө хэлсэн үгийг зөв тохируулж бүтээгээрэй. (2оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Чанарын сайныг хэрэглэхгүй | A | Башир үгтэнг хэрэглэх |
| 2 | Сэтгэлийн сайныг хэрэглэхгүй | B | Олзны сайныг хэрэглэх |
| 3 | Бат зантанг хэрэглэхгүй | C | Царайны сайныг хэрэглэх |
| 4 | Явдлын сайныг хэрэглэхгүй | D | Өнгөний сайныг хэрэглэх |

**1Д, 2С, 3А, 4В**

1. Дараах хүмүүсээс ямар ямар овогтон үүссэнийг нөхөж бичнэ үү. (2 оноо)

Бэлгэнүдэй .......**БЭЛГЭНҮД**............ Жадын хүн ..........**ЖАДАРАН.**.....................

Бодончар мунхаг ..**БОРЖИГОН**.... Дува сохорын 4 хөвгүүнээс ....**ДӨРВӨД**......

9. Дараах эхийг кирилл бичгээр хөрвүүлэн бичээрэй. (5 оноо)

Ах минь дайнд яваад эргэж ирээгүй. Тэгээд би гурил элдэж сурсан юм. МИний зуурсан гурил бас цав цагаан голын чулуу шиг мөлгөрхөн боловч ер халуун болдоггүй байлаа. Тэгээд нэг өдөр гурилаа халуун болтол нухахаар шийдлээ. Эрт гэгч гурилаа зуураад эгчийн үнээгээ саах байх хооронд удаан гэгч нухаж билээ

Алдаатай үг бүрээс 0,25 оноо хасаж тооцно.